

БОГД БАНК ХК

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

БОГД БАНК ХК

БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД	Лувсанвандангийн Болдхуяг Ганбаатарын Саруул Дэмчигжавын Моломжамц Базарсадын Ойгонжаргал Жан Торстэн Дазер Рэнцэндоржийн Баясгалан Жамбалсүрэнгийн Нарантуяа Рожер Томас Мойес Филипп Кахэн
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	Мягмарсүрэнгийн Дэлгэрмөрөн
АЛБАН ХАЯГ	Бодь цамхаг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол Улс
АУДИТОРУУД	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Богд Банк ХК (цаашид “Банк” гэх)-ны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Банкны санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

Ганбаатарын Саруул
Гүйцэтгэх Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр



Моломжамцийн Бат-Өлзий
Санхүү Хариуцсан Захирал



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бүс Аудиторын Тайлан

Богд Банк ХК-ийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Богд Банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлан нь Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бүс Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Банкнаас хараат бүс байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Банкны тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Банкнийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Банкны удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Банкны дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Банкны тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Банкныг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.



Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр

Баталгаажуулсан:

Татьяна Яковлева
Захирал

Баталсан:

Ким Сон Минь
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Богд Банк ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Ашиг, Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

	Тод.	2025 мян.төг	2024 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	3	168,441,703	123,989,119
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(104,256,209)	(70,607,387)
Хүүний цэвэр орлого		64,185,494	53,381,732
Хураамж ба шимтгэлийн орлого	5	2,899,859	3,006,660
Хураамж ба шимтгэлийн зардал	5	(1,229,961)	(1,174,958)
Шимтгэл ба хураамжийн цэвэр орлого		1,669,898	1,831,702
Арилжааны цэвэр орлого	6	2,369,899	5,068,632
Үйл ажиллагааны бусад орлого	7	8,200,999	4,401,721
Нийт үйл ажиллагааны орлого		76,426,290	64,683,787
Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт/(зардал)	8	2,257,683	(1,178,412)
Үйл ажиллагааны цэвэр орлого		78,683,973	63,505,375
Үйл ажиллагааны зардал	9	(23,190,958)	(19,480,399)
Татварын өмнөх ашиг		55,493,015	44,024,976
Орлогын албан татварын зардал	10	(4,389,285)	(3,820,242)
Тайлант жилийн ашиг		51,103,730	40,204,734
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах):			
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):			
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт</i>			
	27	1,085,377	215,657
<i>Ашиг алдагдлын тайлан руу дахин ангилагдах өрийн хэрэглүүрийн гарз</i>			
	27	(74,169)	(932,753)
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		1,011,208	(717,096)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		52,114,938	39,487,638
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төг):			
Нэгж хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг (дахин тайлагнасан)			
	11	436.37	333.41

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Богд Банк ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Байдлын Тайлан

	Тод.	2025.12.31 мян.төг	2024.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	12	161,137,101	186,154,472
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	13	330,552,616	140,317,279
Санхүүгийн хөрөнгө оруулалт	14	136,138,226	85,355,108
Урвуу репо хэлцэл	14	14,054,885	—
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	15	11,339,326	556,858
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	651,114,907	577,211,015
Бусад хөрөнгө	17	33,814,675	30,930,434
Борлуулах зорилготой хөрөнгө	18	23,868,209	32,469,935
Үндсэн хөрөнгө	19	4,339,282	4,820,835
Ашиглах эрхтэй хөрөнгө	20	3,109,723	3,273,780
Биет бус хөрөнгө	21	1,599,406	1,491,954
НИЙТ ХӨРӨНГӨ		1,371,068,356	1,062,581,670
ӨР ТӨЛБӨР			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	22	263,256,035	130,539,362
Репо хэлцэл	23	32,055,531	92,146,247
Харилцагчдын харилцах, хадгаламж	24	555,205,941	453,815,120
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	15	1,787,195	1,346,323
Зээлээр авсан эх үүсвэр	25	299,426,679	206,416,433
Бусад өр төлбөр	26	7,595,380	4,274,540
Түрээсийн өр төлбөр	20	2,966,332	3,211,160
Орлогын татварын өр төлбөр	10.2	2,669,848	1,726,282
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,164,962,941	893,475,467
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувьцаат капитал	27	86,518,250	93,538,567
Бусад нөөц сан	27	4,050,855	1,991,676
Хуримтлагдсан ашиг		115,536,310	73,575,960
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		206,105,415	169,106,203
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		1,371,068,356	1,062,581,670

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Богд Банк ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

	Хувьцаат капитал мян. төг (Тод. 27)	Бусад нөөц сан мян. төг (Тод. 27)	Хуримтлагд- сан ашиг мян. төг	Нийт өөрийн хөрөнгө мян. төг
2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	93,538,567	1,991,676	73,575,960	169,106,203
Тайлант жилийн ашиг	—	—	51,103,730	51,103,730
Бусад дэлгэрэнгүй орлого	—	1,011,208	—	1,011,208
Зохицуулагч байгууллагын журмын сан	—	1,047,971	(1,047,971)	—
Ногдол ашиг (Тод. 27)	—	—	(8,095,409)	(8,095,409)
Халаасны хувьцаа (Тод. 27)	(7,020,317)	—	—	(7,020,317)
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	86,518,250	4,050,855	115,536,310	206,105,415
2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	98,556,822	1,830,472	41,226,149	141,613,443
Тайлант жилийн ашиг	—	—	40,204,734	40,204,734
Бусад дэлгэрэнгүй орлого	—	(717,096)	—	(717,096)
Зохицуулагч байгууллагын журмын сан	—	878,300	(878,300)	—
Ногдол ашиг (Тод. 27)	—	—	(6,976,623)	(6,976,623)
Халаасны хувьцаа (Тод. 27)	(5,018,255)	—	—	(5,018,255)
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	93,538,567	1,991,676	73,575,960	169,106,203

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Богд Банк ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн Гүйлгээний Тайлан

		2025	2024
	Тод.	мян.төг	мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		55,493,015	44,024,976
<i>Тохируулгууд:</i>			
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт борлуулсны олз, цэвэр	6	(1,642,956)	(3,559,745)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	6	—	340,505
Ногдол ашгийн орлого	6	(57,608)	(30,993)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний олз	7	(3,106,580)	(668,325)
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	7	(3,041)	(56,093)
Борлуулах зориулалттай хөрөнгө борлуулсаны олз	7	(4,819,839)	(4,675,838)
Хүлээгдэж буй зээлийн алдагдлын цэвэр (буцаалт)/зардал	8	(2,257,683)	1,178,412
Үндсэн хөрөнгийн элэгдэл	9	1,315,365	1,131,257
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9	612,892	372,756
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	9	1,934,908	1,485,057
Данснаас хассан үндсэн хөрөнгө	9	671	—
Цэвэр хүүгийн орлого	3, 4	(64,185,494)	(53,381,732)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус гарз	7	22,699	1,087,325
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны алдагдал		(16,693,651)	(12,752,438)
Эргэлтийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Монголбанкинд заавал байлгах нөөц		(36,272,203)	(5,044,590)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		(189,080,691)	(80,037,991)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон борлуулах зориулалттай хөрөнгө		(52,263,226)	(268,944,997)
Бусад хөрөнгө		(3,010,983)	(8,793,101)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		132,354,268	114,141,738
Харилцагчдын харилцах, хадгаламж		96,807,031	88,298,416
Репо хэлцэл		(69,718,271)	48,023,183
Бусад өр төлбөр		3,290,733	(2,144,380)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр, цэвэр		(8,067,269)	184,718
Үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(142,654,262)	(127,069,442)
Орлогын албан татварын төлөлт	10.2	(3,445,719)	(3,253,162)
Зээлийн хүү төлөлт		(98,497,778)	(63,247,054)
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт		(739,214)	(714,197)
Хүлээн авсан хүү		158,296,772	119,917,171
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(87,040,201)	(74,366,684)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Богд Банк ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн Гүйлгээний Тайлан (Үргэлжлэл)

		2025	2024
	Тод.	мян.төг	мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт		(240,263,729)	(310,605,125)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	19	(871,801)	(2,274,367)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	21	(720,344)	(906,131)
Үндсэн хөрөнгө борлуулснаас орсон мөнгө		40,359	697,509
Хүлээн авсан ногдол ашиг	6	57,608	30,993
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулснаас орсон мөнгө		<u>244,998,437</u>	<u>318,078,659</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		<u>3,240,530</u>	<u>5,021,538</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт		157,981,913	114,846,947
Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт		(59,265,626)	(40,386,415)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт		(1,890,138)	(1,203,271)
Ногдол ашгийн төлөлт	27	(8,095,409)	(6,976,623)
Халаасны хувьцаа эргүүлэн худалдан авалт	27	<u>(7,020,317)</u>	<u>(5,018,255)</u>
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		<u>81,710,423</u>	<u>61,262,383</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		(2,089,248)	(8,082,763)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12	<u>150,243,765</u>	<u>158,326,528</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12	<u>148,154,517</u>	<u>150,243,765</u>
МӨНГӨН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА			
Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийн нэмэгдэл		1,644,935	1,004,617
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс борлуулах зориулалттай хөрөнгөд шилжүүлсэн	18	—	2,362,878
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс үүссэн өр төлбөрийн хөдөлгөөн:			
Түрээсийн өр төлбөр			
01 дүгээр сарын 01		3,211,160	3,409,558
Мөнгөн бус нэмэгдсэн/хасагдсан		1,644,935	1,004,617
Тайлант жилийн хүүний зардал		739,589	714,453
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт		(739,214)	(714,197)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөр төлөлт		<u>(1,890,138)</u>	<u>(1,203,271)</u>
12 дугаар сарын 31		<u>2,966,332</u>	<u>3,211,160</u>
Зээлээр авсан эх үүсвэр			
01 дүгээр сарын 01		206,416,433	128,957,763
Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт		157,981,913	114,846,947
Үндсэн төлбөр төлөлт		(59,265,626)	(40,386,415)
Хүүний төлөлт		<u>(19,716,105)</u>	<u>(9,820,916)</u>
Эргэн төлөлт, цэвэр		79,000,182	64,639,616
Гадаад валютын ханшийн тэгшитгэл		<u>(7,584,415)</u>	<u>1,229,180</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ		(7,584,415)	1,229,180
Хуримтлагдсан хүүний өглөг		<u>21,594,479</u>	<u>11,589,874</u>
12 дугаар сарын 31		<u>299,426,679</u>	<u>206,416,433</u>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.